



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БШУ	Боловсрол шинжлэх ухааны

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Зөвлөмж.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/115-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,335,302.30	28,729,484.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	29,209.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	20,306,093.30	28,729,484.80
35100	Түүхий эд материал	18,498,093.30	19,338,726.78
35110	Тусгай зориулалттай материал	18,498,093.30	19,338,726.78
35400	Хангамжийн материал	1,808,000.00	9,390,758.02
35420	Аж ахуйн материал	1,808,000.00	2,278,000.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	7,112,758.02
36	НӨӨЦИЙН БАРАА	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	753,866,785.60	820,359,293.89
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	753,866,785.60	820,359,293.89
39200	Биет хөрөнгө	737,586,185.60	788,078,693.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	613,151,801.20	613,151,801.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51,367,675.92)	(76,599,962.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,562,499.68)	0.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	116,348,328.40	138,244,728.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,174,309.32)	(33,459,625.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,980,748.70	68,144,385.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,382,795.62)	(26,289,331.30)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,873,900.00	13,873,900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6,088,731.81)	(8,409,667.65)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	53,843,324.00	53,843,324.00
39217	Ном	29,401,595.65	31,016,642.45
39300	Биет бус хөрөнгө	16,280,600.00	32,280,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,280,600.00	32,280,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	774,202,087.90	849,088,778.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	774,202,087.90	849,088,778.69
51	Засгийн газрын хувь оролцоо	774,202,087.90	849,088,778.69
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	335,538,988.20	335,538,988.20
51200	Хуримтлагдсан үр дүн	(532,172,434.84)	(456,933,642.85)
51210	Өмнөх үеийн үр дүн	(506,207,670.93)	(531,820,333.64)
51220	Тайлант үеийн үр дүн	(25,964,763.91)	74,886,690.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	970,835,534.54	970,483,433.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	774,202,087.90	849,088,778.69

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	787,800,511.18	890,565,104.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,085,811.18	109,258,304.86
120	Нийтлэг татварын бус орлого	10,085,811.18	109,258,304.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,085,811.18	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,085,811.18	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6,524,526.88	97,729,015.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,561,284.30	11,529,289.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	777,714,700.00	781,306,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,820,100.00	650,602,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	684,820,100.00	650,602,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	12,085,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,500,000.00	0.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	7,985,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	548,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,052,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,394,600.00	118,618,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,894,600.00	118,618,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	500,000.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	813,765,275.09	815,678,414.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	813,765,275.09	815,678,414.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,295,598.59	777,609,622.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,314,369.03	517,400,221.00
210101	Үндсэн цалин	371,972,286.55	309,596,010.00
210102	Нэмэгдэл	122,636,408.92	178,706,891.00
210104	Урамшуулал	46,705,673.56	29,097,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,182,446.47	68,328,796.00
210201	Тэтгэврийн даатгал	47,916,499.12	48,318,736.62
210202	Тэтгэмжийн даатгал	5,526,738.51	5,360,796.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,558,459.55	4,140,797.47
210204	Ажилгүйдлийн даатгал	849,060.28	955,314.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,331,689.01	9,553,150.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,225,900.00	117,618,500.00
210301	Гэрэл, цахилгаан	4,732,525.00	4,943,500.00
210302	Түлш, халаалт	72,317,475.00	92,675,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,175,900.00	20,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,210,390.00	10,535,597.70
210401	Бичиг хэрэг	411,050.00	723,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,734,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	386,000.00	1,442,500.00
210404	Ном, хэвлэл	272,300.00	3,186,421.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,702,000.00	660,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,705,040.00	3,323,175.94

2105	Нормативт зардал	683,700.00	3,135,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	683,700.00	2,375,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	760,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,564,900.00	3,370,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	484,900.00	0.00
210604	Урсгал засвар	7,080,000.00	3,370,400.00
2107	Томилолт, зочны зардал	277,900.00	287,500.00
210702	Дотоод албан томилолт	277,900.00	287,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,875,000.00	9,758,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,049,000.00	9,110,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,960,993.09	47,174,507.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,273,100.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,741,000.00	2,695,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,946,893.09	44,478,807.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,469,676.50	38,068,792.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,167,450.00	30,543,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,467,450.00	30,143,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,302,226.50	7,525,642.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,302,226.50	7,525,642.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(22,169,863.91)	74,886,690.79
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(22,169,863.91)	74,886,690.79

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	778,038,100.00	781,306,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	778,038,100.00	781,306,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	684,820,100.00	650,602,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,323,400.00	12,085,800.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,500,000.00	0.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	7,985,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	548,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	323,400.00	3,052,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,394,600.00	118,618,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	84,894,600.00	118,618,500.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	500,000.00	0.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,038,100.00	778,454,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,038,100.00	778,454,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,080,673.50	740,385,208.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,214,168.03	517,400,221.00
210101	Үндсэн цалин	371,872,085.55	311,372,173.00
210102	Нэмэгдэл	122,636,408.92	177,315,417.00
210104	Урамшуулал	46,705,673.56	28,712,631.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,211,655.47	68,299,587.00
210201	Тэтгэврийн даатгал	47,945,708.12	48,289,527.62
210202	Тэтгэмжийн даатгал	5,526,738.51	5,360,796.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,374,350.55	4,140,797.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,169.28	955,314.90
210205	Эрүүл мэндийн даатгал	10,331,689.01	9,553,150.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,225,900.00	117,618,500.00
210301	Гэрэл, цахилгаан	4,732,525.00	4,943,500.00
210302	Түлш, халаалт	72,317,475.00	92,675,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,175,900.00	20,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,666,350.00	6,213,900.00
210401	Бичиг хэрэг	411,050.00	723,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	386,000.00	1,742,500.00
210404	Ном, хэвлэл	695,700.00	385,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,702,000.00	660,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,671,600.00	1,645,000.00
2105	Нормативт зардал	683,700.00	1,498,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	683,700.00	738,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	760,500.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,977,900.00	16,470,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,979,900.00	13,100,000.00
210602	Тавилга	17,100,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	7,080,000.00	3,370,400.00
2107	Томилолт, зочны зардал	277,900.00	287,500.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	277,900.00	287,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,875,000.00	9,758,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,049,000.00	9,110,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,250,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,948,100.00	2,695,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,343,100.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,605,000.00	2,695,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,957,426.50	38,068,792.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,655,200.00	30,543,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,955,200.00	30,143,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	700,000.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,302,226.50	7,525,642.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,302,226.50	7,525,642.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,471,500.00	2,852,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,471,500.00	2,852,800.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,835,534.54	(506,207,670.93)	800,166,851.81
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(25,964,763.91)	(25,964,763.91)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,835,534.54	(532,172,434.84)	774,202,087.90
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,835,534.54	(532,172,434.84)	774,202,087.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	352,101.20	352,101.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	(352,101.20)	0.00	(352,101.20)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	74,886,690.79	74,886,690.79
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	(456,933,642.85)	849,088,778.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	769,221,000.00	769,221,000.00	-	100.00%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	769,221,000.00	769,221,000.00	-	100.00%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,575,400.00	731,152,208.00	6,423,192.00	99.13%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	519,456,100.00	517,400,221.00	2,055,879.00	99.60%
210101	Үндсэн цалин	327,745,300.00	311,372,173.00	16,373,127.00	95.00%
210102	Нэмэгдэл	162,830,900.00	177,315,417.00	(14,484,517.00)	108.90%
210104	Урамшуулал	28,879,900.00	28,712,631.00	167,269.00	99.42%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,666,900.00	68,299,587.00	4,367,313.00	93.99%
210201	Тэтгэврийн даатгал	50,691,500.00	48,289,527.62	2,401,972.38	95.26%
210202	Тэтгэмжийн даатгал	5,493,900.00	5,360,796.61	133,103.39	97.58%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,395,100.00	4,140,797.47	254,302.53	94.21%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,098,800.00	955,314.90	143,485.10	86.94%
210205	Эрүүл мэндийн даатгал	10,987,600.00	9,553,150.40	1,434,449.60	86.94%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,618,500.00	117,618,500.00	-	100.00%
210301	Гэрэл, цахилгаан	6,348,600.00	4,943,500.00	1,405,100.00	77.87%
210302	Түлш, халаалт	91,269,900.00	92,675,000.00	(1,405,100.00)	101.54%
210303	Цэвэр, бохир ус	20,000,000.00	20,000,000.00	-	100.00%
2104	Хангамж, бараа материалын зардал	5,856,200.00	5,856,200.00	-	100.00%
210401	Бичиг хэрэг	425,400.00	425,400.00	-	100.00%
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00	-	100.00%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,742,500.00	1,742,500.00	-	100.00%
210404	Ном, хэвлэл	385,200.00	385,200.00	-	100.00%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	458,100.00	458,100.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,645,000.00	1,645,000.00	-	100.00%
2105	Нормативт зардал	950,600.00	950,600.00	-	100.00%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	190,100.00	190,100.00	-	100.00%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,500.00	760,500.00	-	100.00%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,310,400.00	16,310,400.00	-	100.00%
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,100,000.00	13,100,000.00	-	100.00%

210604	Урсгал засвар	3,210,400.00	3,210,400.00	-	100.00%
2107	Томилолт, зочны зардал	287,500.00	287,500.00	-	100.00%
210702	Дотоод албан томилолт	287,500.00	287,500.00	-	100.00%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,733,500.00	1,733,500.00	-	100.00%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,085,500.00	1,085,500.00	-	100.00%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00	-	100.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,695,700.00	2,695,700.00	-	100.00%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,695,700.00	2,695,700.00	-	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,645,600.00	38,068,792.00	(6,423,192.00)	120.30%
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,645,600.00	30,543,150.00	1,102,450.00	96.52%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,245,600.00	30,143,150.00	1,102,450.00	96.47%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	-	100.00%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	7,525,642.00	(7,525,642.00)	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	7,525,642.00	(7,525,642.00)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	-	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	769,221,000.00	769,221,000.00	-	100.00%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	650,602,500.00	650,602,500.00	-	100.00%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	650,602,500.00	650,602,500.00	-	100.00%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	118,618,500.00	118,618,500.00	-	100.00%
320001	Орон нутгийн төсвөөс	118,618,500.00	118,618,500.00	-	100.00%
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1.00	1.00	-	100.00%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	46.00	1.00	97.87%
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	34.00	3.00	91.89%
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	100.00%
630001	Төрийн өмчит ЕБС	569.00	569.00	-	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.00	0.00	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		12,085,800.00	(12,085,800.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		12,085,800.00	(12,085,800.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,085,800.00	(12,085,800.00)
2104	Хангамж, бараа материалын зардал		500,000.00	(500,000.00)
210401	Бичиг хэрэг		298,000.00	(298,000.00)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		202,000.00	(202,000.00)
2105	Нормативт зардал		548,000.00	(548,000.00)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		548,000.00	(548,000.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		160,000.00	(160,000.00)
210604	Урсгал засвар		160,000.00	(160,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,877,800.00	(10,877,800.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,877,800.00	(10,877,800.00)
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		12,085,800.00	(12,085,800.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		12,085,800.00	(12,085,800.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		548,000.00	(548,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,485,000.00	(8,485,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,052,800.00	(3,052,800.00)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Б.Батцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хичээлийн сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулахад багш бүрийн хөгжлийг дэмжин, эцэг эхийн үүрэг нэмэгдүүлэх хамтран ажиллах, суралцагчдын сурлагын чанарыг нэмэгдүүлэх” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе

шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 813,765.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,137.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,696.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,886.7 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	29.2		(29.2)

Бараа материал	20,306.1	28,729.5	8,423.4
Үндсэн хөрөнгө	753,866.7	820,359.3	66,492.6
Нийт хөрөнгө	774,202.1	849,088.8	74,886.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	774,202.1	849,088.8	74,886.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	774,202.1	849,088.8	74,886.7

Авлага дансны үлдэгдэл 29.2 мянган төгрөгөөр буурсан нь цалингаас суутгасан НДШ-ийн авлагыг барагдуулснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 8,423.4 мянган төгрөгөөр өссөн нь БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 5,621.8 мянган төгрөгийн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 4,357.5 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, ариутгалын материал, Ерөө сумын Засаг даргын тамгын газраас 1,400.0 мянган төгрөгийн оношлуур, Бугант Арвижих –с 150.0 мянган төгрөгийн халуун хэмжигчийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 44,874.7 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 47,980.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 40,675.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БСШУЯ-с 1,472.8 мянган төгрөгийн сурах бичиг, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 1,530.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Ерөө сумын ОНХС-с 6,000.0 мянган төгрөгийн, Бугант Нандин ХХК-с 10,000.0 мянган төгрөгийн барилгын зураг төсвийн үнэ, Хан хэнтий хамгаалалтын газраас 2,270.0 мянган төгрөгийн, эцэг эхийн хандиваар 6,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 13,242.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 849,088.8 мянган төгрөг болж 74,886.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 98,969.7 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хөрөнгө, бараа материал нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,913.1 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн нь түлш халаалт, цэвэр бохир усны зардал өссөн нь голлон шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 971,110.4 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Сургуулийн сургалтын үйл ажиллагаа нь танхим болон танхимын бус үйл ажиллагаанд шилжүүлсэнтэй холбоотойгоор төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр **769,221.0** мянган төгрөгийн төсөв баталснаас 650,602.5 мянган төгрөгийг улсын төсвөөс /тусгай зориулалтын шилжүүлгээр/, 118,618.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 650,602.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 118,618.5 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 769,221.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 761,695.4 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 7,525.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **761,695.4** мянган төгрөг буюу 99.0 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ын зардал 6,423.2 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 1,102.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал халдваргүйжүүлэлт 500.0 мянган төгрөг, БШУЯ-наас “Боловсролын чанарын шинэчлэл” төсөлд 7,985.0 мянган төгрөг, Ерөө сумын ЗДТГ-с ариутгалын зардалд 548.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын хоёрдугаар хавсралт “Коронавируст халдварын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу хичээл сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

2.Өндөр настны тэтгэвэр тогтоолгон ажиллаж байгаа 5 багшид 1,616.1 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалин олгосон байна. Уг албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 36.2.2 дахь заалтын дагуу өндөр настны тэтгэврээ тогтоолгож, төрийн албанаас бүр мөсөн чөлөөлөгдсөн тул цаашид шаардлагатай гэж үзвэл төрийн албаны шатлалаар бус ажил гүйцэтгүүлэх гэрээний үндсэн дээр төрийн албаны ямар нэгэн нэмэгдэл цалин, урамшуулалгүйгээр ажлын хөлсийг харилцан тохиролцож тогтмолоор тогтоон ажиллах нь зүйтэй юм.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуульд 769,221.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 761,695.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.0 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Шууд худалдан авах босго үнээс давсан 15,817.7 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтад харьцуулалтын арга хэрэглээгүй, тендерийн урилгыг нийтэд зарлалгүйгээр шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх *“Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”*, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн 2 дахь *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа 10,0 сая төгрөг”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,807.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,771.8 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 325.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 акт тогтоож, 17,710.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тайланд 2,771.8 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын тайлан үйлдээгүй байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Захирлын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/50 дугаар тушаалаар оны тэргүүнээр шалгарсан 3 багшид дотоод журамд заасан хэмжээнээс илүү тооцон, 325.0 мянган төгрөгийн шагнал олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, Дотоод журмын 10.2.11 дэх *“жил бүр эрхэлсэн ажилдаа амжилт гарган хамт олноо хошуучилсан багш, ажилчдаас “Оны тэргүүний багш”, “Тэргүүний ажилтан” нэг нэгийг шалгаруулж тус бүр 25,000 төгрөгөөр шагнаж урамшуулна”* “гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон мөнгөн шагналыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 17,710.5 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх

1.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.2.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7-д гэсэн заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ерөө сумын Бугант тосгоны Ерөнхий боловсролын сургууль	4	20,807.4	1	2,771.8	1	325.0			2	17,710.6

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.